Палеонтологийн хүрээлэнгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 309,623.9 мянган төгрөгөөр буюу 1.07 хувиар өссөн 39байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	366,601.6	-	(366,601.6)
Авлага	11.6	17,978.3	17,966.7
Урьдчилгаа	14,042.7	34,818.8	20,776.1
Үндсэн хөрөнгө	3,820,797.0	4,457,980.4	637,183.4
Нийт хөрөнгө	4,356,099.5	4,665,723.4	309,623.9
Өр төлбөр	-	420.3	420.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,356,099.5	4,665,303.0	309,203.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,356,099.5	4,665,723.4	309,623.9

Мөнгөн хөрөнгө данс үлдэгдэлгүй болж, 366,601.6 мянган төгрөгөөр буурсан нь нэмэлт санхүүжилт дансны үлдэгдэл 366,601.6 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгийн худалдан авалтыг зохих зөвшөөрлийн дагуу хийсэнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 17,978.3 мянган төгрөг болж, 17,966.7 мянган төгрөгөөр өссөн нь Геологийн судалгааны төвтэй хамтран ажиллах гэрээт ажлын авлага 17,938.3 мянган төгрөг, ажилтанд илүү олгосон 40.0 мянган төгрөгийг авлагаар бүртгэснээс шалтгаалжээ.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 34,818.8 мянган төгрөг болж, 20,776.1 мянган төгрөгөөр өссөн нь албан томилолтын урьдчилгаа 30.0 мянга, “Эйр транс” ХХК-д шилжүүлсэн нислэгийн тасалбарын үнийн 10,284.0 мянга, “Номин стандарт дизайн” ХХК-д урьдчилж төлсөн “Монголын палеонтологи” эрдэм шинжилгээний бүтээлийн ном хэвлүүлэх 9,770.0 мянга, Хас банканд байршуулсан томилолтын зардлын 10,544.4 мянга, “Петро стар” ХХК-д шатахууны картад 4,190.4 мянган төгрөгийн үлдэгдэл байна. Энэ нь Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын хөл хорио эхэлж олон улсын нислэг, номын хэвлэлт, томилолтын ажил тодорхойгүй хугацаагаар хойшилсонтой холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,457,980.4 мянган төгрөг болж, 637,183.4 мянган төгрөгөөр өссөн нь урсгал төсвийн худалдан авалтаар 39,933.0 мянга, БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй хүлээн авсан 13,891.6 мянга, ТӨБЗГ-ын №539 тоот тушаалаар ашиглах боломжтой, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг данснаас хасаж дахин үнэлж үнэ төлбөргүй орлого, хөрөнгийн залруулга 285,352.3 мянга, болон нэмэлт санхүүжилт буюу өөрийн орлогоос үндсэн хөрөнгүүд худалдан авсан 366,413.2 мянга, тайлант хугацаанд 68,406.7 мянган төгрөгийн элэгдлийн зардал гарснаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 420.3 мянган төгрөг болж, 420.3 мянган төгрөгөөр өссөн нь хээрийн судалгааны ажлын машины түрээсийн зардлыг гэрээний дүнгээс дутуу шилжүүлснээс шалтгаалжээ.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 4,520,737.8 мянган төгрөг болж, 309,203.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 273,062.3 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

Палеонтологийн хүрээлэнгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 3,093,585.9 мянган төгрөгөөр буюу 63.5 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан дараах орлогууд байна. Үүнд:

- Төсвийн санхүүжилтийн орлого өмнөх оноос 733,997.5 мянган төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 2019 оны 328 дугаар тогтоолоор Палеонтологи, Геологийн хүрээлэнг салгаж, бие даасан 2 хүрээлэн болгосноос шалтгаалсан байна. Эхний үлдэгдэл 2019 оны 8 дугаар сарын 14-өөс 12 дугаар сарын 31-нээрх орлого тусгагдсантай холбоотой байна.
- Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого нь өмнөх оноос 3,497,740.8 мянган төгрөгөөр буурсан байгаа нь өмнөх онд балансаас балансад 3,796,984.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалыг шилжүүлэн авч, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэснээс шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 998,877.8 мянган төгрөгөөр буюу 2.7 дахин өссөн байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 328 дугаар тогтоолын дагуу бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор 2019 оны санхүүгийн тайланд 9 сараас 12 сар дуусталх хугацааны гүйцэтгэл тусгагдсан бол 2020 онд бүтэн жилийн зардал тусгагдсантай холбоотойгоо зардлын бүх дансуудад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан 36,141.3 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга нь 2019 онд газар эзэмших эрх дээр элэгдэл байгуулсныг залруулснаас шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 944,989.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 944,989.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төсөлд өөрчлөлт оруулаагүй, 944,989.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 944.989.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 944.989.6 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 944.989.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 918,568.8 мянган төгрөгийг зарцуулж, үндсэн санхүүжилтээс 26,420.8 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 2,096.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 918,568.8 мянган төгрөг буюу 97.2 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 5,361.1 мянга, хангамж, бараа материалын зардлыг 492.5 мянга, Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 7,740.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хураамжийн зардлыг 12,682.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 228,616.5 мянга, Сангийн Яамны Төрийн сангийн нэгдсэн дансанд байсан үзэсгэлэнгийн орлогын үлдэгдлийг нэмэлт санхүүжилтийн данс руу шилжүүлэн оруулснаас 366,601.6 мянга, нийт 595,218.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс гэрээт ажлын хөлсөнд 173,641.0 мянга, нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 20,276.4 мянга, хангамж, бараа материалын зардалд 1,080.1 мянга, эд хогшил, урсгал засварын зардалд 189,507.8 мянга, томилолт, зочны зардалд 15,074.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт 193,542.9 мянга, нийт 593,122.1 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 2,096.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 178 мэдээллээс хугацаандаа оруулсан 139 мэдээлэл, хугацаа хоцроосон 30 мэдээлэл, 9 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,405.0 мянган төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	1,405.0	2	1,405.0	-	-	-
Нийт дүн	2	1,405.0	2	1,405.0	-	-	-

/мянган.төг/

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 184,477.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 144,565.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 14,871.8 мянган төгрөгийн зөрчилд 4 акт тогтоож, 1 албан шаардлага хүргүүлж, 25,040.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Газар эзэмших 216,847.8 мянган төгрөгийг эрхийг 2019 оноос хойш 144,564.1 мянган төгрөгийн элэгдэл тооцсоныг аудитын явцад залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 14,871.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 14,871.8 мянган төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт, 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Америкийн Нэгдсэн Улсад болох арга хэмжээнд оролцохоор “Эйр транс” ХХК-д 2019 оны 12 дугаар сарын 25-нд нислэгийн тасалбарын үнийн 10,284.0 мянган төгрөг шилжүүлсэн боловч уг арга хэмжээ тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон байхад төлбөрийг буцааж аваагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-д “Төсвийг нэг жилээр баталж, тайлагнах бөгөөд батлагдсан төсвийг сар, улирлаар хуваарилан, хэрэгжилтийг зохион байгуулна”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

2. Нэр бүхий 23 ажилчдад 2,800.5 мянган төгрөгийн цалин, ээлжийн амралтын олговрыг давхардуулж олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1-д “Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ” гэсэн заалт, Эрүүл мэнд нийгэм хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалаар батлагдсан “Ээлжийн амралт олгох заавар” 13-д “Ажил олгогч нь ажилтан ажлаас халагдахаас бусад тохиолдолд болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол биеэр эдлүүлээгүй амралтын оронд мөнгөн олговор олгож болохгүй” гэсэн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

3. Нэр бүхий 43 ажилчдад 1,384.0 мянган төгрөгийн хоолны мөнгө илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

4. Шатахууныг норм лимитээр тооцож олгоогүйгээс 403.3 мянган төгрөгийг илүү олгосон нь Зам тээвэр, хөгжлийн сайдын 2018 оны 390 дүгээр тушаал, Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

5. Шилэн дансанд 30 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэлд мэдээлэл огт байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “Тогтсон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.10-т “Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна.” гэсэн заалттай нийцэхгүй, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 25,040.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Тус хүрээлэн нь хээрийн томилолтын зардлыг арилжааны банканд байршуулдаг ба тус дансанд 10,544.4 мянган төгрөг үлдэгдэлтэй гарсан байгаа нь анхаарал татсан болно.

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаатай холбоотой аудит хийх цар хүрээ хязгаарлагдаж, байгууллага дээр ажиллаж хөрөнгийн биет тооллого хийх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Цалингийн зардалтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Хүрээлэнгийн захирал нь Засгийн газрын 2019 оны 472 болон 276 дугаар тогтоолын дагуу ТҮШУ-5 зэрэглэлээр 1,038,6 мянган төгрөгийн цалин авах байтал Шинжлэх Ухааны Академийн Ерөнхийлөгчийн 2018 оны тушаалыг үндэслэн 1,200.0 мянган төгрөгийн үндсэн цалин авч байна.

1.2. Эрсдэл:

Цалинг Засгийн газраас тогтоон цалингийн сүлжээний дагуу олгоогүй байх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Монгол Улсын Засгийн Газрын 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл”, 472 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт “Шинжлэх ухааны байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээ”-ын дагуу үндсэн цалинг тогтоож, олгох.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлтэй танилцаж В501 маягтаар алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрсөн

2. Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт

2.1. Илрүүлэлт:

Хамаарал бүхий 1 этгээдтэй 2020 оны 06 дугаар сарын 04-ны ПХ/202005006 дугаартай Хээрийн судалгааны ажлын хэрэгцээнд багаж туслах хэрэгсэл худалдах, худалдан авах 15,000.0 мянган төгрөгийн гэрээг байгуулж худалдан авалт хийсэн байна.

2.2. Эрсдэл:

Ашиг сонирхлын зөрчилтэй гэрээ байгуулж худалдан авалт хийсэн байх.

2.3. Өгсөн зөвлөмж:

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлтэй танилцаж В501 маягтаар алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрсөн.

3. Зардлын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Түүвэрт хамрагдсан 41 харилцагчтай холбоотой 548,185.8 мянган төгрөгийн гүйлгээг татварын цахим системд бүртгэгдсэн төлбөрийн баримттай тулгахад 7 харилцагчтай холбоотой 7,086.0 мянган төгрөгийн төлбөрийн цахим баримтыг харилцагчаас гаргуулан аваагүй;

3.2. Эрсдэл:

Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй гүйлгээг бүртгэлд тусгасан байх

3.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 5 “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэсэн заалтын дагуу төлбөрийн баримтгүй ажил гүйлгээ хийхгүй байх, харилцагч байгууллагаас бүрэн гаргуулан авахад хяналт тавьж ажиллах;

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлтэй танилцаж В501 маягтаар алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Палеонтологийн Хүрээлэнгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			САГ-2021/86/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Палеонтологийн Хүрээлэн		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1		2	3	4	5
1	Нэр бүхий 23 ажилтанд 2,800.5 мянган төгрөгийн цалин, ээлжийн амралтын олговрыг давхардуулж олгосон байна	2,800.5	Төлбөрийн акт тогтоох	Захирал Нягтлан бодогч	Х.Цогтбаатар Э.Батчимэг
2	Нэр бүхий 43 хүнд 1,384.0 мянган төгрөгийн хоолны мөнгө илүү олгосон нь байна.	1,384.0	Төлбөрийн акт тогтоох	Захирал Нягтлан бодогч	Х.Цогтбаатар Э.Батчимэг
3	Шатахууныг норм лимитээр тооцож олгоогүйгээс 403.3 мянган төгрөгийг илүү олгосон байна.	403.3	Төлбөрийн акт тогтоох	Захирал Нягтлан бодогч	Х.Цогтбаатар Э.Батчимэг
4	Америкийн Нэгдсэн Улсад болох арга хэмжээнд оролцохоор “Эйр транс” ХХК-д 2019 оны 12 дугаар сарын 25-нд нислэгийн тасалбарын үнийн 10,284.0 мянган төгрөг шилжүүлсэн боловч уг арга хэмжээ тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон байхад төлбөрийг буцааж аваагүй байна.	10,284.0	Төлбөрийн акт тогтоох	Захирал Нягтлан бодогч	Х.Цогтбаатар Э.Батчимэг
5	Шилэн дансанд 30 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэлд мэдээлэл огт байршуулаагүй байна.	-	Албан шаардлага	Захирал Нягтлан бодогч	Х.Цогтбаатар Э.Батчимэг
6	Тус хүрээлэнгийн эрдэм шинжилгээний дэд ажилчинтай 2020 оны 06 дугаар сарын 04-ны ПХ/202005006 дугаартай "Хээрийн судалгааны ажлын хэрэгцээнд багаж туслах хэрэгсэл худалдах, худалдан авах" 15,000.0 мянган төгрөгийн гэрээг байгуулж худалдан авалт хийсэн байна.	15,000.0	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Х.Цогтбаатар Э.Батчимэг

7	Хүрээлэнгийн захирал нь Засгийн газрын 2019 оны 472 болон 276 дугаар тогтоолын дагуу ТҮШУ-5 зэрэглэлээр 1,038.6 мянган төгрөгийн цалин авах байтал Шинжлэх Ухааны Академийн Ерөнхийлөгчийн 2018 оны тушаалыг үндэслэн 1,200.0 мянган төгрөгийн цалин авч байна.	2,960.8	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Х.Цогтбаатар Э.Батчимэг
8	Тайлант оны 548,185.8 мянган төгрөгийн худалдан авалтыг и-баримттай тулган шалгахад 7,079.7 мянган төгрөгийг и-баримтад бүртгээгүй байна.	7,079.7	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Х.Цогтбаатар Э.Батчимэг
ДҮН		39,912.3			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 02 дугаар сарын 25

№ 45/АД/160058

Улаанбаатар хот

САГ-2021/86/СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Палеонтологийн Хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэр бүхий 23 ажилтанд цалин, ээлжийн амралтын олговрыг давхардуулж 2,800,500.00 (хоёр сая найман зуун мянга таван зуун) төгрөг, нэр бүхий 43 ажилтанд хоолны мөнгөний 1,384,000.00 (нэг сая гурван зуун наян дөрвөн мянган) төгрөг, шатахууны норм лимитээс 403,300.00 (дөрвөн зуун гурван мянга гурван зуун) төгрөгийг тус тус илүү олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1-д "Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ", Эрүүл мэнд нийгэм хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалаар батлагдсан "Ээлжийн амралт олгох заавар"-ын 13-д "Ажил олгогч нь ажилтан ажлаас халагдахаас бусад тохиолдолд болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол биеэр эдлүүлээгүй амралтын оронд мөнгөн олговор олгож болохгүй", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-д "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын "Автомашинуы 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Akt\2021\0225auditin 2-R Газар41.Docx

001090505

1. Илүү олгосон 4,587,800.00 (дөрвөн сая таван зуун наян долоон мянга найман зуун) төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газар¹ т ирүүлэхийг Палеонтологийн Хүрээлэнгийн захирал Х.Цогтбаатар, нягтлан бодогч Э.Батчимэг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


Ц.НАРАНЧИМЭГ

АХЛАХ АУДИТОР

Б.СЭРЖМЯДАГ

“УВАА УУЛ АУДИТ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ,
АУДИТОР

Ч.МӨНХТУЯА



¹ Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас: 51-264230

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 02 дугаар сарын 25

№ 44/АД/60058

Улаанбаатар хот

САГ-2021/85/СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Палеонтологийн Хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Палеонтологийн Хүрээлэн нь Америкийн Нэгдсэн Улсад болох арга хэмжээнд оролцохоор “Эйр транс” ХХК-д 2019 оны 12 дугаар сарын 25-нд нислэгийн тасалбарын үнийн 10,284,000.00 (арван сая хоёр зуун наян дөрвөн мянган) төгрөгийг шилжүүлсэн боловч уг арга хэмжээ зохион байгуулагдаагүй, тодорхойгүй хугацаагаар хойшлогдож, уг төлбөрийг буцааж аваагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-д “Төсвийг нэг жилээр баталж, тайлагнах бөгөөд батлагдсан төсвийг сар, улирлаар хуваарилан хэрэгжилтийг зохион байгуулна”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Палеонтологийн Хүрээлэнгийн “Эйр транс” ХХК-д шилжүүлсэн 10,284,000.00 (арван сая хоёр зуун наян дөрвөн мянган) төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Палеонтологийн Хүрээлэнгийн захирал Х.Цогтбаатар, нягтлан бодогч Э.Батчимэг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АХЛАХ АУДИТОР
“УВАА УУЛ АУДИТ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ,
АУДИТОР

Б.СЭРЖМЯДАГ

Ч.МӨНХТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Akt\2021\0225auditin 2-R Газар40.Docx

001090502



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 151/АО160058
САГ-2021/86/СТА – ТМЗ
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Палеонтологийн Хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын шилэн дансанд байршуулбал зохих 178 мэдээллээс 30 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Мөн нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэлд мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “Тогтсон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.10-т “Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж мэдээллийг ил тод, цаг хугацаанд нь бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Палеонтологийн Хүрээлэнгийн захирал Х.Цогтбаатар, нягтлан бодогч Э.Батчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ

“УВАА УУЛ АУДИТ” ХХК-ийн ЗАХИРАЛ,
АУДИТОР

Ч.МӨНХТУЯА

